

## **Товч танилцуулга**

"Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл"-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийн талаар

### **1. Ерөнхий агуулга, зохицуулах харилцаа, зарчмын шинжтэй зохицуулалт:**

Уг хуулийн төсөл нь 1 зүйлтэй.

Хуулийн төсөлд "Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл"-ийг хэрэгжүүлэх 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлахаар тусгасан.

Энэхүү "Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл"-ийн Санхүүгийн хэлэлцээр нь Олон улсын гэрээний тухай хуулийн 8.1.2-т заасан "гадаад улс, олон улсын байгууллага, гадаад улсын болон олон улсын банк, санхүүгийн байгууллагаас авах зээлийн ерөнхий нөхцөлийн талаархи олон улсын гэрээ"-нд хамаарах тул Улсын Их Хурал соёрхон батлах хуулийн зохицуулалттай болно.

### **2. Тухайн харилцааг урьд нь хууль, эрх зүйн бусад актаар зохицуулж ирсэн байдал:**

"Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл"-ийг хэрэгжүүлэх 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах харилцаа тул тус харилцааг урьд нь хууль, эрх зүйн актаар зохицуулаагүй болно.

### **3. Хуулийн төслийг боловсруулахтай холбогдуулан хууль санаачлагчаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:**

Төслийг хэрэгжүүлэгч төрийн захиргааны төв байгууллагууд хамтран тус төслийн Санхүүгийн хэлэлцээрийг хийж, Засгийн газрын 2023 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн хуралдаан, Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаан, Төсвийн байнгын хороо, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн хамтарсан хуралдаанаар хэлэлцүүлсэн болно. Мөн Монгол Улсын Ерөнхий сайдын 162 дугаар захирамжийг үндэслэн Санхүүгийн хэлэлцээрт Сангийн сайд Б.Жавхлан 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдөр гарын үсэг зурсан.

### **4. Хуулийн төслийг олон нийтээр хэлэлцүүлсэн дүн:**

"Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл"-ийг хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийг соёрхон батлах тухай

хуулийн төслийг гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудын төлөөлөл, олон нийтийн дунд 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Онцгой байдлын ерөнхий газар дээр зохион байгуулан, хэлэлцүүлэн хийж, саналыг авсан. Түүнчлэн, Сангийн яам болон Онцгой байдлын ерөнхий газрын цахим хуудсанд холбогдох мэдээллийг байршуулан, саналыг авсан болно.

**5. Гадаад орны туршлага, бусад судалгаа, шинжилгээний тайлангийн дүгнэлт:**

Уг хуулийн төсөлд тусгасан "Онцгой байдлын ерөнхий газрын агаараас аврах ангид нэмэлт сургалт явуулах төсөл"-ийг хэрэгжүүлэх 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хэлэлцээрийн хүрээнд Онцгой байдлын ерөнхий газраас хэрэгжүүлэхтэй холбоотой бусад судалгааг хийсэн.